



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
/төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	/төгрөгөөр/ ..5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/ .6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	/төгрөгөөр/ .8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын зардлын худалдан авалт, зарцуулалтын тооцооллыг шалгах горимыг дараагийн аудитаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын өргөө, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг - 18090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgoviaudit.gov.mn

2024-02-05 № 07

Тайлан № _____

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 152 дугаар тогтоолоор “Ган-Илч” ХХК-ны дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж баталснаас халаалтын өглөг үүссэн байна. Мөн Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тус байгууллага хөрөнгө худалдан авах гэрээ байгуулан төлбөрийг бүрэн шилжүүлсэн ч бэлтгэн нийлүүлэгч тал хөрөнгөө нийлүүлээгүй асуудал аймгийн Цагдаагийн газарт хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн мөрдөн байцаалтын шатанд явж байгаа нь аудитын гол асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

002-249016

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт, 57 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 84.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,429,442.69	105,923,123.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		5,571,163.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		5,571,163.06
3121	Төгрөг		5,571,163.06
31211	Төрийн сангийн харилцах		5,571,163.06
33	АВЛАГА	14,352,991.69	17,697,765.19
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,963,500.10
335	Бусад авлага	14,352,991.69	15,734,265.09
3351	Байгууллагаас авах авлага	3,852,095.20	4,924,817.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,500,896.49	10,809,447.69
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	74,076,451.00	82,654,195.00
351	Түүхий эд материал	27,035,865.00	27,695,865.00
3511	Тусгай зориулалттай материал	24,481,350.00	25,141,350.00
3513	Эм боох материал	2,554,515.00	2,554,515.00
354	Хангамжийн материал	47,040,586.00	54,958,330.00
3541	Бичиг хэргийн материал	3,751,241.00	4,194,641.00
3542	Аж ахуйн материал	38,458,827.00	44,996,471.00
3543	Сэлбэг хэрэгсэл	2,571,500.00	2,956,500.00
3545	Барилгын засварын материал	2,259,018.00	2,810,718.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,838,697,380.76	5,812,337,867.74
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,838,697,380.76	5,812,337,867.74
392	Биет хөрөнгө	5,763,037,089.03	5,737,921,416.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,782,433,271.39	6,917,249,058.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,266,181,936.00	1,582,058,464.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,274,800.00	168,274,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,111,500.13	-71,127,444.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,597,390.00	259,841,878.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,237,478.94	-58,312,199.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,022,862.00	73,770,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,008,818.13	-23,018,262.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,185,000.00	53,694,950.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,936,501.16	-393,499.05
393	Биет бус хөрөнгө	75,660,291.73	74,416,451.74
39301	Програм хангамж	1,300,000.00	5,386,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,055,208.19	-182,991.68
39303	Бусад биет бус хөрөнгө	100,265,200.00	100,265,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-24,849,700.08	-31,052,381.58
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,927,126,823.45	5,918,260,990.99
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,790,060.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,790,060.06
413	Өглөг		9,790,060.06
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		9,787,060.06
4136	Бусад өглөг		3,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		3,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,927,126,823.45	5,908,470,930.93
51	Засгийн газрын хувь оролцоо	5,927,126,823.45	5,908,470,930.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	479,936,623.37	479,936,623.37
51101	Өмч: - төрийн	479,936,623.37	479,936,623.37
512	Хуримтлагдсан үр дүн	4,657,006,484.20	4,638,350,591.68
5121	Өмнөх үеийн үр дүн	4,657,006,484.20	4,656,630,986.20
5122	Тайлант үеийн үр дүн		-18,280,394.52
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,183,715.88	790,183,715.88

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,927,126,823.45	5,918,260,990.99
----	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,506,835.81	921,650,173.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,343,815.39	339,047,126.06
120	Нийтлэг татварын бус орлого	68,343,815.39	339,047,126.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		11,187,041.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,215,878.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		4,471,163.06
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	67,293,815.39	324,395,821.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,050,000.00	3,464,264.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	502,163,020.42	582,603,047.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,354,320.42	55,751,647.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,258,500.00	16,961,380.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,095,820.42	33,790,267.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	438,808,700.00	526,851,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	438,808,700.00	526,851,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	847,909,285.32	939,638,150.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847,909,285.32	939,638,150.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,962,587.20	903,679,160.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,290,227.54	333,544,872.08
210101	Үндсэн цалин	182,205,103.54	229,128,384.18
210102	Нэмэгдэл	46,031,947.00	86,367,527.90
210104	Урамшуулал	17,053,177.00	18,048,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,012,230.70	41,229,737.35
210201	Тэтгэврийн даатгал	20,620,218.37	28,407,854.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,427,069.08	3,342,100.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,942,055.19	2,674,580.62
210204	Ажилгүйдлийн даатгал	456,346.46	615,564.71
210205	Эрүүл мэндийн даатгал	4,566,541.60	6,189,636.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,110,401.89	61,246,435.17
210301	Гэрэл, цахилгаан	4,400,746.09	7,187,775.11
210302	Тулш, халаалт	37,916,055.80	51,459,460.06
210303	Цэвэр, бохир ус	1,793,600.00	2,599,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,928,989.72	22,040,290.00
210401	Бичиг хэрэг	2,840,074.00	2,671,300.00
210402	Тээвэр, шатахуун	11,529,890.00	14,344,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,118,952.57	2,243,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,356,600.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,885,900.00	841,220.00
210408	Бараа материал акталсны зардал	11,197,573.15	
2105	Нормативт зардал	1,551,750.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,551,750.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,743,910.00	5,452,600.00
210602	Тавилга	69,110.00	
210604	Урсгал засвар	4,674,800.00	5,452,600.00
2107	Томилолт, зочны зардал	7,464,000.00	12,620,000.00
210702	Дотоод албан томилолт	7,464,000.00	12,620,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,225,232.40	27,563,054.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,256,540.00	25,308,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,450.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,374.40	119,074.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	222,868.00	235,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	409,635,844.95	399,982,171.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,347,044.00	19,944,255.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	1,305,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	374,488,800.95	378,732,916.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,946,698.12	35,958,990.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,879,938.50	9,153,650.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		3,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,368,850.00	3,953,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,194,700.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,316,388.50	1,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,066,759.62	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,066,759.62	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		26,805,340.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		26,805,340.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-277,402,449.51	-17,987,977.09
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	199,875.00	
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	199,875.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,390,398.49	292,417.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	26,390,398.49	292,417.43
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-26,190,523.49	-292,417.43
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-303,592,973.00	-18,280,394.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	498,444,425.22	591,373,317.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		10,943,764.06
120	Нийтлэг татварын бус орлого		10,943,764.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		10,943,764.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,972,601.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		4,471,163.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	498,444,425.22	580,429,553.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,635,725.22	53,578,153.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,258,500.00	16,961,380.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,377,225.22	31,616,773.30
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	438,808,700.00	526,851,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	438,808,700.00	526,851,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	523,474,356.25	557,532,154.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,474,356.25	557,532,154.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,532,708.13	521,573,164.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,294,275.54	335,213,872.18
210101	Үндсэн цалин	182,209,151.54	230,797,384.18

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	46,031,947.00	86,367,527.90
210104	Урамшуулал	17,053,177.00	18,048,960.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,666,286.13	41,524,237.35
210201	Тэтгэврийн даатгал	20,620,218.37	28,671,354.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,427,069.08	3,373,100.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,942,055.19	2,674,580.62
210204	Ажилгүйдлийн даатгал	4,566,541.60	615,564.71
210205	Эрүүл мэндийн даатгал	44,110,401.89	6,189,636.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,110,401.89	51,459,375.11
210301	Гэрэл, цахилгаан	4,400,746.09	7,187,775.11
210302	Түлш, халаалт	37,916,055.80	41,672,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,793,600.00	2,599,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,377,842.57	24,258,470.00
210401	Бичиг хэрэг	2,736,000.00	3,114,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,529,890.00	14,344,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,118,952.57	2,243,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,356,600.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,636,400.00	2,616,000.00
2105	Нормативт зардал	300,000.00	650,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,605,000.00	5,138,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,150,000.00	
210604	Урсгал засвар	4,455,000.00	5,138,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,464,000.00	12,620,000.00
210702	Дотоод албан томилолт	7,464,000.00	12,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,105,858.00	27,560,054.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,256,540.00	25,305,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,450.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.00	119,074.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	222,868.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр		235,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,609,044.00	23,148,655.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,809,044.00	21,843,655.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	1,305,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,941,648.12	35,958,990.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,874,888.50	9,153,650.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		3,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,363,850.00	3,953,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,194,700.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,316,338.50	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,066,759.62	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,066,759.62	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		26,805,340.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		26,805,340.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-25,029,931.03	33,841,163.06
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (5)	18,500,000.00	28,270,000.00
	Дотоод эх үүсвэрээр	18,500,000.00	28,270,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,500,000.00	28,270,000.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-18,500,000.00	-28,270,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-43,529,931.03	5,571,163.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,571,163.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,282,993.14	5,034,657,533.99	
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-99,277.26		
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			-377,486,232.05	
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,183,715.88	4,657,006,484.20	5,927,126,823.45
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-375,498.00	-375,498.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
17	Тайлант үеийн үр дүн			-18,280,394.52	-18,280,394.52
18	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,183,715.88	4,638,350,591.68	5,908,470,930.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	534,422,900.00	532,224,001.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,422,900.00	503,954,001.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526,222,900.00	484,927,486.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,370,800.00	335,213,872.18
210101	Үндсэн цалин	234,609,500.00	230,797,384.18
210102	Нэмэгдэл	87,693,300.00	86,367,527.90
210104	Урамшуулал	15,068,000.00	18,048,960.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,740,500.00	41,524,237.35
210201	Тэтгэврийн даатгал	28,641,800.00	28,671,354.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,373,900.00	3,373,100.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,719,900.00	2,674,580.62
210204	Ажилгүйдлийн даатгал	635,900.00	615,564.71
210205	Эрүүл мэндийн даатгал	6,369,000.00	6,189,636.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,961,600.00	46,781,297.62
210301	Гэрэл, цахилгаан	2,877,000.00	2,509,697.62
210302	Түлш, халаалт	41,672,400.00	41,672,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,150,500.00	2,599,200.00
210304	Байрны түрээс	2,261,700.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	31,347,000.00	19,260,270.00
210401	Бичиг хэрэг	3,120,000.00	3,114,700.00

210402	Тээвэр, шатахуун	12,197,000.00	11,015,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,830,000.00	1,593,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,600,000.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000.00	1,596,000.00
2105	Нормативт зардал	650,000.00	650,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,913,200.00	5,138,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,773,200.00	
210604	Урсгал засвар	5,140,000.00	5,138,500.00
2107	Томилолт, зочны зардал	13,566,000.00	11,630,000.00
210702	Дотоод албан томилолт	13,566,000.00	11,630,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,793,000.00	2,254,854.40
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,000.00	119,074.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	372,000.00	235,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,880,800.00	22,474,455.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,652,100.00	21,169,455.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,228,700.00	1,305,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,200,000.00	19,026,514.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,200,000.00	9,153,650.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,500,000.00	3,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,050,000.00	3,953,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	1,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		9,872,864.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,872,864.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		28,270,000.00
	Дотоод эх үүсвэрээр		28,270,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	531,602,275.00	537,795,164.06
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	527,251,400.00	526,851,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	527,251,400.00	526,851,400.00
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,350,875.00	10,943,764.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,350,875.00	2,972,601.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		4,471,163.06
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,571,163.06

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		53,578,153.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		53,578,153.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,645,677.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,678,077.49
210301	Гэрэл, цахилгаан		4,678,077.49
2104	Хангамж, бараа материалын зардал		4,998,200.00
210402	Тээвэр, шатахуун		3,328,200.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,020,000.00
2105	Нормативт зардал	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	
2107	Томилолт, зочны зардал	990,000.00
210702	Дотоод албан томилолт	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,305,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,305,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	674,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	674,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,932,475.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,932,475.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	
	Дотоод эх үүсвэрээр	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,578,153.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,578,153.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,961,380.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,616,773.30
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо "Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж, тасралтгүй суралцагч алба байхад оршино" гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад өөрчлөлт ороогүй. Харин төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой дараах тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн тайлант оноос дагаж мөрдөхөөр,
- Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтүүд,
- Засгийн газрын 2023 оны 240 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийдэг, тус онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,865.8 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	5,571.2	5,571.2
Авлага	14,353.0	17,697.8	3,344.8
Бараа материал	74,076.5	82,654.2	8,577.7
Үндсэн хөрөнгө	5,838,697.4	5,812,337.9	(26,359.5)
Нийт хөрөнгө	5,927,126.8	5,918,261.0	(8,865.8)
Өр төлбөр	-	9,790.1	9,790.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,927,126.8	5,908,470.9	(18,655.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,927,126.8	5,918,261.0	(8,865.8)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,571.2 мянган төгрөгөөр өссөн нь Ахмадын сангийн санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26,359.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 28,270.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 324,395.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгасантай холбоотой байна. Мөн тайлант онд 378,732.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулж, тайлагнажээ.

Өр төлбөрийн данс 9,790.1 мянган төгрөг болж өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 152 дугаар тогтоолоор “Ган-Илч” ХХК-ны дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж баталснаас халаалтын өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,908,470.9 мянган төгрөг болж 18,655.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 453,640.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 7,843.5 мянган төгрөгөөр бууруулж, 445,796.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 88,626.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 534,422.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Энэ нь төрийн албан хаагчид олгох орон нутагт ажилласны нэмэгдлийг оны эхнээс олгох, мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өсөлтөөс шалтгаалсан байна

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 526,851.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 10,943.8 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг 532,224.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай зарцуулж, 9,872.8 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.6 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101[1]	319,219.5	311,940.8	7,278.7	97.7
80106[2]	83,669.0	82,691.3	977.7	98.8
80112[3]	86,112.9	84,855.7	1,257.2	98.5
80714[4]	3,500.0	3,500.0	-	100.0
80801[5]	4,050.0	3,953.7	96.3	97.6
80802[6]	1,700.0	1,700.0	-	100.0
81102[7]	17,000.0	16,897.1	102.9	99.4
82212[8]	11,600.0	11,440.0	160.0	98.6
-	534,422.9	532,224.0	9,872.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 16,961.4 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 31,616.8 мянган төгрөг, гаднын хандиваар 5,000.0 мянган төгрөг, нийт 53,578.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 36,645.7 мянган төгрөгийг зарцуулж, 16,932.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Угтахбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүү, үр дүнгийн тайлангийн нийт зардал 938,170.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,381.7 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 9,396.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Энэ нь санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотой байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн 99.6 хувийг зарцуулж, 9,872.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ. Төсвийг 99.6 хувьтай зарцуулсны дийлэнх хувь нь үндсэн үйл ажиллагааны зардлын хэмнэлт байна.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд нийт 654,263.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулж, хэрэгжилт 100.0 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,232.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, аудитын явцад 375.5 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй. Харин аудитын явцад 1,381.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн худалдан авалт, элэгдлийн тооцооллыг шалгах, завсарын аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтэд биет горимыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,470.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 11,013.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 5,762.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3 хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 11,013.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

1. Төрийн албаны зөвлөлийн дансанд төвлөрүүлсэн зөрчилтэй томилгооны 375.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайлангаас хаагаагүй.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 10,637.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 5,762.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,262.5 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Тооллогоор дутагдсан 500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн үнийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 /*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ заасныг зөрчсөн.

5.2 Албан шаардлага

1. Хөрөнгө худалдан авах гэрээ байгуулан төлбөрийг бүрэн шилжүүлсэн ч бэлтгэн нийлүүлэгч тал 2,898.0 мянган төгрөгийн хөрөнгөө нийлүүлээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/, Худалдах, худалдан авах гэрээний 4-т /*тавилга, эд хогшил нийлүүлэх ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 08-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгнө*/ заасныг;
2. Зарцуулсан 1,334.5 мянган төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ заасныг;
3. Шатахууны зардлаас үндсэн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд зарцуулж, 1,030.0 мянган төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ заасныг зөрчсөн зэрэг зөрчлүүдэд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн албаны зөвлөлийн дансанд төвлөрүүлсэн зөрчилтэй томилгооны авлагыг санхүүгийн тайлангаас хаагаагүй.	1	375.5			1	375.5	1	375.5				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг цэвэрлэх бичилт хийгээгүй	1	10,637.9			1	10,637.9	1	10,637.9				
Дүн	2	11,013.4	-	-	2	11,013.4	2	11,013.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооллогоор дутагдсан тээврийн хэрэгслийн үнийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлээгүй.	1	500.0	1	500.0								
Хөрөнгө худалдан авах гэрээ байгуулан төлбөрийг бүрэн шилжүүлсэн ч бэлтгэн нийлүүлэгч тал хөрөнгөө нийлүүлээгүй.	1	2,898.0			1	2,898.0						
Зарцуулсан бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан.	1	1,334.5			1	1,334.5						
Шатахууны зардлаас үндсэн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	1,030.0			1	1,030.0						
Дүн	4	5,762.5	1	500.0	3	5,262.5						